Бага, дунд орлоготой орнуудад тохиолдох Коронавируст халдвар (COVID-19)-тай эмчлүүлэгсдийг бөөрний цочмог гэмтэцээс урьдчилан сэргийлэх, эмчлэх хялбаршуулсан зааварчилгаа

Кристинс Руд[1], ЕлифЧизмец [2], Габриела Гали[3], Ганболд Лүндэг[4], Маркус Шульц[5,6], Алфред Папали[7]

[1]Питтсбургийн Их Сургууль, Амь тэнссэн үеийн анагаах ухаан судлалын тэнхим, Питтсбург, АНУ
[2]Торонтогийн Их Сургууль, Амь тэнссэн үеийн анагаах ухаан судлалын салбар, Канад
[3]Питтсбургийн Их Сургууль, Анагаах Ухааны Сургууль, Питтсбург, АНУ
[4] АШУҮИС, Яаралтай тусламж, мэдээгүйжүүлэг судлалын тэнхим, Улаанбаатар, Монгол
[5]Махидолын Их Сургууль, Халуун орны эмнэлзүйн анагаахын тэнхим, Тайланд
[6]Махидол-Оксфордын Эмнэлзүйн судалгааны төв (MORU)
[7] Шарлотте "Atrium Health", Амь тэнссэн үеийн анагаах ухаан судлалын тэнхим, АНУ
ganbold@mnums.edu.mn

Хураангуй

Коронавирус(COVID-19)-ын халдварын улмаас бөөрний цочмог гэмтэц (БЦГ) учирсантохиолдолд өвчтөнүүдийг эмчлэх тухай боловсруулан гаргасан өвлөмжүүд нь ихэвчлэн өндөр орлоготой орнуудад нөөц хангамж сайтай, эрчимт эмчилгээний тасгаас гаргасан нотолгоон дээр үндэслэгдэж байна.

Эдгээр зөвлөмжүүдийг бага, дунд орлоготой орнууд(БДОО)-ын нөөц хязгаарлагдмал нөхцөлд эмнэлзүйн практик үйл ажиллагаанд хэрэглэх боломж бололцоо хомс, ач холбогдол багатай байдаг. БДОО-уудад тохиолдох коронавирусын халдварын үеийн бөөрний цочмог гэмтэцээс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх талаарх практик зөвлөмжүүдийн бид боловсруулан гаргасан болно.

Коронавирусын халдвар авсан эмчлүүлэгсдийг бөөрний цочмог гэмтлээс урьдчилан сэргийлэх зорилгоор орчих цусны эзлэхүүнийг нэмэгдүүлэн заалтаар коллойд шингэнээс илүүтэй кристаллойд уусмалыг судсаар сэлбэх шингэн болгон сонгон авах, амьсгалын дутагдалтай өвчтөнүүдэд шингэн сэлбэх хэмжээг эрс бууруулах, өвчтөний шингэний тэнцвэрийг сөрөг үзүүлэлтэй байлгахыг зөвлөж байна.

БДОО-уудад учрах COVID-19 халдвар авсан эмчлүүлэгсдийн дунд креатинины түвшин нэмэгдсэн бол БЦГ-тэй хэмээн үзэж тохирох эмчилгээг хугацаа алдахгүй эхлүүлэх заалттай.

Дээрх өвчтөнийг эмчлэх явцдаа цаашид ялган оношилгоо хийх замаар тухайн тохиолдолд БЦГ байсан эсэхийг тодруулна. COVID-19 халдвартай бөөрний үйл ажиллагааны алдагдалтай өвчтөнүүдэд БЦГ-ийг оношлохын тулд бололцоотой нөхцөлд сийвэнгийн креатинин, шүлсний мочевины (ихэнх БДОО-д хийдэг нам технологийн шинжилгээ-ред.) хэмжээг тодорхойлох шинжилгээг ЭМАШТ-ийн хүрээнд хэрэгжүүлэх шаардлагатай. Эрүүл мэндийн тусламж үзүүлдэг бүх шатны байгууллагын ажилтнууд БЦГ-ийн илрүүлэх, эмчлэх арга аргачлалд суралцаж зохих мэдлэгийг эзэмшсэн байх хэрэгтэй.

БДОО-д тохиолдох COVID-19 халдвартай БЦГ-тэй үйлчлүүлэгчдэд сэлбэх шингэний хэмжээг нямбай тохируулан, шингэн сэлбэлтийн хэмжээг хэтрүүлэхгүйгээр зүгшрүүлэхийг зөвлөж байна. Коронавирус (COVID-19)-ын хүнд хэлбэрийн халдвартай, амьсгалын дутагдалтай тохиолдолд боломжтой тохиолдолд уушги хамгаалах дэгээр механик амьсгалуулалт хийх замаар цитокиноос үүдэлтэй бөөрний гэмтлээс сэргийлэхийг санал болгож байна.

Амьсгалын цочмог дистресс хамшинж (АДХШ) илэрсэн, COVID-19 халдвартай үед БЦГ-ийг эмчлэх эхний сонголт нь диализ эмчилгээ байх бөгөөд шингэнийг нэвчүүлэн (ультрафилтрац) гаргаж сөрөг тэнцлийг үүсгэх бололцоог олгоно. Харин амьсгалын цочмог дистресс хамшинж илрээгүй COVID-19 халдвартай тохиолдолд БЦГ-ийг хэвлийн диализ хийх замаар эмчлэх боломжтой.

УДИРТГАЛ

Бөөрний цочмог гэмтэц (БЦГ) нь амь тэнссэн хүнд эмгэгийн үед хамгийн олонтой тохиолдох хүндрэл бөгөөд эмнэлзүйн дээрх байдалд нас баралтын гол шалтгаан болж байна.[1]Цочмог халдварын нийтлэг хүндрэлүүд болох гипотензи ба шингэн алдалт нь БЦГ-д хөтлөх үндсэн шалтгаан болж байгаа бөгөөд хүнд халдварын улмаас БЦГ үүсэх нь эмнэлзүйн явцыг хүндрүүлэх, эмнэлэгт хэвтэх хугацааг удаашруулах, хэвтэн эмчлүүлэгчдийн нас баралтыг нэмэгдүүлэх шалтгаан болно.[1-3]

Томуу, томуу төст зэрэг амьсгалын замын бусад халдваруудын[4-5] нэгэн адил коронавирусын хүнд халдвартай хүмүүст БЦГ үүсдэг хийгээд зарим судалгаагаар COVID-19-ийн улмаас эмнэлэгт хэвтэж эмчлүүлж буй өвчтөнүүдийн 3-9% нь БЦГ илэрч, бөөр орлуулах эмчилгээ шаардлагатай болдог.[6-7] COVID-19 халдварын улмаас хэвтэн эмчлүүлэгчдэд халдварын хоёр дахь долоо хоногт БЦГ хамгийн олонтой тохиолддог.[8]

COVID-19 халдвартай өвчтөнд БЦГ үүсэхэд олон хүчин зүйл нөлөөлөх бөгөөд үүнд вирус бөөрний эсийг гэмтээх, шингэний алдагдал-дутал, үжлийн шалтгаант гипотензи эсвэл иммунологийн гарвалтай гэмтэц, бичил судасны эмгэг өөрчлөлт зэргээс хамаарна гэж үздэг.[9-10] COVID-19 халдвар авагсдад үзүүлэх тусламж үйлчилгээнд БЦГ-ийг эрт илрүүлэх, хүндрэлээс урьдчилан сэргийлэх, зүгшрүүлэх эмчилгээг хугацаа алдалгүй эхлүүлэх цаашид бөөрний дутагдал (БД)-ын шатанд орвол орлуулах эмчилгээг хийх зэргийг хамруулан ойлгоно.

Эмнэлзүйн тэргүүн эгнээнд ажиллаж буй эмч нар шингэний зүгшрүүлэг, вирусын эсрэг эмүүд, хавсарсан халдварыг эмчлэх антибиотик, үрэвслийг бууруулах зэрэг олон төрлийн эмчилгээний эрсдэл, ашиг тусыг тэнцвэржүүлэхийг эрмэлзэнэ. Эмчилгээний дээрх бүрэлдэхүүн хэсэг тус бүр өөрийн гэсэн онцлогтой, тулгамдах бэрхшээлтэй байх тул эмнэлзүйнэдгээрчухал бүрэлдэхүүн хэсгүүдийн харилцан үйлчлэлийг анхааран үзэх шаардлагатай.

Эмнэлзүйд тулгарах дээрх бэрхшээлүүдийн зэрэгцээ хүний нөөц дутагдах болон эм, багаж хэрэгслэлийн нөөц шавхагдах зэрэг нь хүндээр нөлөөлнө. COVID-19 халдвартай өвчтөнүүдэд тохиолдох БЦГ-ийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, тусламж үзүүлэх-эмчлэх талаар БДОО-д хийсэн судалгаа, хэвлэн нийтэлсэн нотолгоог энд тоймлон үзүүлэв.

Арга зүй

Бид БДОО-ын хүрээнд COVID-19-ийн сэжимтэй эсвэл батлагдсан өвчтөнүүдэд тохиолдох БЦГ-ийн онцлогийг илтгэх багц асуултыг боловсруулсан. Эдгээр асуултуудын боловсруулж “БДОО-уудад тохиолдох COVID-19 өвчнийг талаарх судалгааны ажлын хэсэг”-ийн бусад гишүүдэд хянуулав.

Багийн гишүүдийн саналыг авсны дараа “COVID-19 халдварын үеийн БЦГ”-ийг судлах дэд бүлгээс гишүүд асуулт тус бүрээр нотлох баримтыг PubMed ба OVID интернетийн санд хайлт хийж холбогдох нотолгоог цуглуулав. Хэвлэлийн хайлтыг “COVID-19”, “амьсгалын замын бусад вирусууд”, “халдвартай холбоотой тохиолдох БЦГ” зэрэг үгээр хайж холбогдох нотолгоо, нийтлэлүүдийг сонгон боловсруулсан болно.

Холбогдох эх сурвалжийн нотолгооны чанарыг хүчтэй, дунд зэрэг, сул хэмээн хуваасан бөгөөд боловсруулан гаргаж буй зөвлөмжийг өндөр, дунд, бага зэрэглэлтэй хэмээн ангилаад өндөр зэрэглэлийн зөвлөмжийг ***“бид зааварчилж....”*** байна, сулхан зэрэглэлийн зөвлөмжийг ***“бид зөвлөмжилж....”*** байна гэсэн үгүүдээр илэрхийлж оруулсан байна.Бид боловсруулсан зөвлөмжөө “БДОО-д тохиолдох COVID-19 өвчнийг талаарх судалгааны ажлын хэсэг”-ийн бусад гишүүдэд дахин давтан хянуулж саналыг тусгасны эцэст хэвлэн нийтэлж байна.

Асуултууд

Бид COVID-19 халдварын үед тохиолдох БЦГ-ийн талаар дараах дөрвөн асуултыг боловсруулан гаргасан:

1. БДОО-уудад тохиолдох COVID-19 халдвараар өвчлөгсдийг БЦГ-ээс урьдчилан сэргийлэх ямар арга аргачлал байна вэ?
2. БДОО-уудад тохиолдох COVID-19 халдвараар өвчлөгсдөд учрах БЦГ-ийг хэрхэн оношлох вэ?
3. БДОО-уудад COVID-19 халдварын улмаас БЦГ-ээр хүндэрсэн тохиолдлыг хэрхэн эмчлэх вэ, тэдгээрийн хэнд нь бөөр орлуулах эмчилгээ шаардлагатай вэ?
4. COVID-19 халдварын улмаас БЦГ-д өртсөн өвчтөнүүдэд диализийн хүртээмж, үр ашгийг оновчтой болгох ямар боломжууд байна вэ?
5. Дээрх асуултуудтай холбогдон гарах зааварчилгаа хийгээд зөвлөмжийн талаар энэ өгүүлэлд танилцуулна.

Асуулт 1. БДОО-д тохиолдох COVID-19 халдвараар өвчлөгсдийг БЦГ-ээс урьдчилан сэргийлэх ямар арга аргачлал байна вэ?

Үндэслэл

COVID-19 халдварт хүндээр өртсөн өвчтөнийг БЦГ-ээс хэрхэн урьдчилан сэргийлэх арга аргачлал одоог хүртэл бүрэн тодорхойгүй хэвээр байна. COVID-19 халдвартай холбоотой БЦГ-ийн эмгэг физиологийн талаарх ойлголт улам бүр хөгжиж байгаа бөгөөд тухайн салбарт гарах дэвшлийн үр дүнд дээрх хүндрэлээс урьдчилан сэргийлэх аргыг олж тогтооно хэмээн бид найдаж байна.[9-12]

COVID-19 халдвартай нөхцөлд БЦГ-ийг гарал үүслийг хэд хэдэн механизмаар тайлбарлагддаг бөгөөд үүнд эндотелийн үйл ажиллагааны алдагдал, цус эргэлтийн шок, гиповолеми, цитокиний шуурга, гиперкоагулопатийн улмаас микро бүлэн эсвэл шигдээс үүсэх, ангиотензин хувиргагч фермент 2 (ACE-2) рецепторооос улбаатай эсийн шууд гэмтэл, бөөрний сувганцрын эпителийн цочмог үхжил болон бөөрөнд хортой нөлөө үзүүлэх эмийг үйлдэл зэрэг хамаарагдана.[11,13,14]

Одоогийн байдлаар COVID-19 халдвартай өвчтөнүүдийг БЦГ-ээс урьдчилан сэргийлэх ихэнх арга хэмжээ нь халдвар, халдварын хүндрэл, үжил болон амьсгалын цочмогдутагдлаас урьдчилан сэргийлэхэд чиглэгдэнэ.[13,15]

Хайлтын үр дүн

PubMed ба OVID-ийн мэдээллийн цахим санд хадгалагдах эх сурвалжуудаас 2020 оны 8-р сарын 14-нийг хүртлэх хугацаанд MeSH-ийн нэр томъёоны дагуу хийгээд текстийн дотор агуулагдах үгсийг ашиглан хайлт хийсэн. “Бөөрний цочмог дутагдал”, “COVID-19/SARS CoV-2”, “урьдчилан сэргийлэх”, “хөгжиж буй орнууд” эсвэл эдгээр нэр томъёонд нийцсэн MeSH нэр томьёололын дагуу хайхад шууд холбоотой нотолгоо олоогүй.

Хайлтын хүрээг өрөтгөн «бөөрний цочмог дутагдал», «бага, дунд орлоготой орнууд», «COVID-19 / SARS CoV-2» гэсэн нэр томьёолол бүхий хайлтын явцад тодорхой үр дүнд хүрсэнгүй, Хайлтыг «бөөрний цочмог дутагдал» ба «хөгжиж буй орнууд» болгон өргөжүүлснээр 19 үр дүн, «бөөрний цочмог дутагдал» ба «бага орлоготой орнууд» гэсэнтэй холбоотой 13 үр дүн гарав. Нэг судалгаа дээрх хоёр хайлтанд зэрэг гарч ирэв.

Хайлтын дүнд олдсон нийт 31 судалгаанаас 7 судалгаа хураангуйдхамааралгүй байсан тул хасэгдсан. Үлдсэн 24 судалгаанаас 4 судалгаа ижил гарчигтай байв (нэг өгүүллийг олон сэтгүүлд нэгэн зэрэг хэвлүүлсэн). Үлдсэн 21 судалгааны 8 нь тойм, 3 нь системчилсэн тойм буюу мета анализ, 2 дагах ба 2 эргэх ажиглалтын судалгаа, 3 тайлбар, 2 судалгааны хөтөлбөр (сайжруулан засварласан Дельфийн арга) ба хөндлөн огтлолын дамнасан судалгаа нэг байв. COVID-19 халдвартай холбоотой БЦГ-ийн талаар тусгайлан нийтэлсэн судалгаа олдоогүй.

“Бөөрний цочмог дутагдал”, “COVID-19 / SARS CoV 2”, “урьдчилан сэргийлэх” гэсэн нэр томъёог ашиглан хайлт хийхэд 11 үр дүн гарсан байна. Хайлтыг “бөөрний цочмог дутагдал” болон “COVID-19 / SARS CoV-2” болгон өргөжүүлснээр PubMed дээр 71 үр дүн гарсан бөгөөд үүнээс 9 нь англиас өөр хэлээр хэвлэгдсэн байна. Англи хэлний бус судалгааг хассаны дараа 62 судалгаа үлдсэн. Үүнээс хасах шалгууруар 9 нь хасагдсан. Үлдсэн 53 судалгаанд 10 тойм, 6 системчилсэн тойм, 10 ажиглалтын судалгаа, 1 дагасан ажиглалтын судалгаа, 15 тайлбар/захидал хэлбэрийн, 3 эмнэлзүйн туршилт судалгаа, 2 удирдамж, 6 тохиолдлын тайлан/ тохиолдлын цуврал хэлбэрээр нийтлэгдсэн болно. Дээрх нотолгоо, бүтээлүүдийн аль нь ч БДОО-д хийгдээгүй бөгөөд лавлагаа тойм боловсруулалт хийсээс хойш 22 нэмэлт холбогдох судалгааг нийтлэгдэжээ.

Нотолгоо

COVID-19 халдвар авсан үед тохиолдох БЦГ-ээс урьдчилан сэргийлэх талаар тодорхой нотолгоо хэвлэгдээгүй тул бид халдварын улмаас БЦГ-д хүргэх хүндрэлээс урьдчилан сэргийлэх талаарх тоймыг боловсруулан гаргав. 2012 онд хэвлэгдсэн “Бөөрний эмгэгийг даяршлын эринд эмчлэхүй (KDIGO) удирдамжид БЦГ-д нэрвэгдэх өндөр эрсдэлтэй өвчтөнүүдийн урдчилан сэргийлэх багц арга хэмжээг хэрэгжүүлэхийг зааварчилжээ.[16] Энэхүү багцад: өвчтөний креатинины үзүүлэлт, шээсний хэмжээг тодорхойлох гемодинамикийн үзүүлэлтүүдийг хянах болон орчих цусны эзлэхүүнийг зүгшрүүлэх, бөөрөнд нөлөөлөх эмийн хэрэглээг зогсоох, гипергликеми үүсэхээс сэргийлэх, тодруулагчтай-радио идэвхт бодисуудаас хор хөнөөл багатай сонгох зэргийг хамруулжээ.

Орчих цусны эзлэхүүний хомсдох нь БЦГ-ийн түгээмэл шалтгаан болж байгаа боловч COVID-19 халдвар авсан үед шингэнээр зүгшрүүлэх тусламжийг уламжлалт хийгээд хямагдсан дэгээр хийх аргачлалуудыг

харьцуулсан судалгаа дутагдалтай байна. Ихэнх удирдамжууд нь орчих цусны эзлэхүүнийг хэвийн хэмжээнээс хэтрүүлэхгүй байлгахыг зөвлөж байна учир нь гиповолемийн эхний үе шатанд шингэн хэт их сэлбэх нь шингэний хэт ачаалал үүсгэж нас баралтыг нэмэгдүүлдэг нь нотлогдсон.[17-19]

Санамсаргүй хяналттай туршилтаар шингэнийг нөхөх уламжлалт аргачлал нь уушгинаас бусад эрхтнүүдийн дутагдлыг нэмэгдүүлэхгүйгээр уушгины үйл ажиллагааг шууд бус замаар сайжруулж, амьсгалын цочмог дистресс хамшинж (ARDS)-тэй өвчтөнүүдийн зохиомол амьсгалуулалт, эрчимт эмчилгээний хугацааг богиносгодог болохыг харуулж байна.[20]

БЦГ-ийн дараах эмнэлзүйн шатанд шингэний баланс нэмэх буюу эерэг үзүүлэлттэй байсан өвчтөнүүдийн нас баралт өндөр байгааг судалгаагаар нотолжээ.[21] Шингэний зүгшрүүлэг эмчилгээнд кристаллойд ба коллойдын хоорондын ялгааг харьцуулан судлахад альбуминыг хэрэглэхэд аюулгүй хэдий ч энэ нь кристаллойд хэрэглэхээс илүү үр дүнтэй биш болохыг тогтоожээ.[22] Гидроксэтилийн цардуул(HES)-ыг заримдаа гиповолемийг эмчлэхэд ашигладаг боловч судалгаагаар HES гэх мэт гиперонкотик цардууллаг шингэн нь БЦГ болон нас баралтын эрсдэлийг нэмэгдүүлдэг болохыг нотолжээ.[23]

COVID-19 халдварын үед өвөрмөц өгөгдөл дутагдалтай байгаа ч БЦГ-ийн менежментэд шээс хөөх эм хэрэглэхийг зөвлөдөггүй; COVID-19 халдвартай холбоотой БЦГ-ийн талаарх NICE-ийн удирдамжууд нь орчих цусны эзлэхүүнийг хэвийн хэмжээнд байлгах нь гол зорилго бөгөөд механик амьсгалуулалтыг дэмжих зорилгоор шээс хөөх эм хэрэглэх гэх мэт нь дээрх өвчтөнүүдэд БЦГ-ийн эрсдэлийг нэмэгдүүлдэг гэдгийг анхаарч үзэх шаардлагатай.[24]

БЦГ-ээс урьдчилан сэргийлэх, эмчлэх тухай 2019 оны тойм өгүүлэлд гогцоонд үйлчилдэг шээс хөөх эмийг БЦГ-ээс сэргийлэх, эмчлэх зорилгоор ашиглах нь үр дүн багатай бөгөөд шээс хөөр эмийг БЦГ-ээс урьдчилан сэргийлэхэд ашиглах нь зөвхөн орчих цусны эзлэхүүн хэвийн хадгалагдсан тохиолдолд таатай үр дүнд хүрч болохыг нотолсон юм.[25]

Хэрэгжүүлэх боломж, эрсдэл хүндрэлээс сэргийлэхүй.

Дээр дурдсан БЦГ-ээс сэргийлэх KDIGO-ийн зөвлөмжийн олонх нь хэрэгжүүлэхэд хямд төсөр өртөгтэй боловч нөөц бололцоо нэн хязгаарлагдмал зарим БДОО-уудад хэрэгжүүлэхэд төвөг учирдаг.[16] БДОО-уудад изотоник кристаллойд уусмалын хүрэлцээ хангалттай байдаг. Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс дахь эрчимт эмчилгээний 66 эмнэлэгт хийсэн судалгаагаар кристаллойд уусмалын хангалт 100% байдаг хэмээн дурджээ.[26]

Судсаар хэрэглэдэг кристаллойдын үнэ харьцангуй хямд боловч харилцан адилгүй байдаг. Нэг эх сурвалжид Хлорт натрийн 0.9%-ийн 1 литр уусмал нь ойролцоогоор 1 доллар, Рингер лактат 1 литр нь тутамд дунджаар 1.1 доллар байна гэж мэдээлжээ.[27] Альбумины 5%-ийг шингэний зүгшрүүлэг эмчилгээнд хэрэглэхэд илүү үр нөлөөтэй эсэх талаар одоог хүртэл маргаантай байгаа боловч БДОО-уудын нөхцөлд олдоц, хүртээмж хангалтгүй бөгөөд өртөг өндөртэй байдаг нь тодорхой.

Индонези улсад хийсэн нэг төвт судалгаагаар хумхаа төст халууралттай хүмүүсийн зүгшрүүлэг эмчилгээнд кристаллойдыг дангаар болон кристаллойд ба коллойдыг хослуулан хэрэглэсэн зардлын үр дүнг үнэлэхэд, дундаж ор хоногийн өртөг хоёрдугаар хувилбарын үед 9%-иар илүү байгааг тогтоосон.[30]

Элдэв хүнд халдварт өвчинд хүндээр нэрвэгдэгсдийн орчих цусны эзлэхүүнийг зүгшрүүлэх замаар БЦГ-ээс урьдчилан сэргийлэх аюулгүй, үр дүнтэй аргыг одоог хүртэл бүрэн тодорхойлоогүй хэвээр байна. БДОО-уудад хийсэн хэд хэдэн санамсаргүй тохиолдлын эмнэлзүйн туршилт судалгааныудад эрт үеийн зүгшрүүлэг эмчилгээнд кристаллойд ба коллойд уусмалуудыг богино хугацаанд их хэмжээгээр хэрэглэхэд хоруу нөлөөтэйг харуулсан.[31,32]БДОО-уудад шингэнээр зүгшрүүлэг эмчилгээ хийх тохиромжтой, илүү аюулгүй арга барилыг бий болгох цаашдын судалгаа, нотолгоо шаардлагатай байна.

Зааварчилгаа болон зөвлөмжүүд (Хүснэгт 1)

1. БДОО-уудын нөхцөлд COVID-19 халдвартай өвчтөнүүдийн орчих цусны эзлэхүүнийг нэмэгдүүлэх зорилгоор изотоник кристаллойд уусмал хэрэглэхийг зааварчилж байна *(өндөр зэрэглэлийн зөвлөмж, нотолгооны чанар дунд)*.
2. БДОО-ын COVID-19 халдвартай холбоотой амьсгалын дутагдал болон БЦГ бүхий өвчтөнүүдэд шингэнийг хямгатай сэлбэх (консерватив) аргачлалыг ашиглахыг зөвлөмжилж байна *(өндөр зэрэглэлийн зөвлөмж, нотолгооны чанар дунд)*.

Асуулт 2. БДОО-уудад тохиолдох COVID-19 халдвараар өвчлөгсдөд учрах БЦГ-ийг хэрхэн оношлох вэ?

Үндэслэл

Нөөц, бололцоо хязгаарлагдмал орчинд БЦГ-ийг оношилох нь нэн төвөгтэй, тулгамддаг асуудал мөн. Өмнөх судалгаануудаар өндөр орлоготой улс орнуудтай харьцуулахад зарим БДОО-уудын өвчтөнүүдэд тохиолдох БЦГ-ийг илрүүлж оношлоход хугацаа алддаг, БЦГ-ийг оношлох үеийн ийлдсийн креатинины түвшин харьцангуй өндөр байсан хийгээд диализ эмчилгээг оройтуулж эхлүүлдэг болохыг тогтоожээ.[33-35]

COVID-19 халдварын үеийн БЦГ-ийг шуурхай илрүүлж оношлох шаардлагатай болсон, учир нь дээрх халдвартай өвчтөнүүдэд тохиолдох БЦГ өндөртэй хийгээд энэ хүндрэлийн улмаас өвчтөнүүдийн эмнэлэгт нас барах хувь хэмжээ мэдэгдэхүйц нэмэгддэг байна.[36]

Хайлтын дүн

PubMed-ийн мэдээллийн санд 2020 оны 8-р сарын 17-ныг хүртэлх хугацаанд «бөөрний цочмог дутагдал», «COVID-19», «нөөцийн хязгаарлагдмал» эсвэл MeSH нэр томъёог баримтлан дээрх нэр томъёоны дагуу хайлт хийхэд нэг судалгааны үр дүн олдсон боловч агуулга, зорилтын хүрээнд зөрөөтэй байсан тул хасагдсан болно.

PubMed цахим сангаас “Бөөрний цочмог дутагдал”, “COVID-19”, “БДОО” хэмээх нэршлээр мөн “бөөрний цочмог дутагдал”, “COVID-19”, “бага нөөцтэй тохиргоо” гэсэн нэршлээр хайлт хийхэд үр дүн гарсангүй. “Бөөрний цочмог дутагдал” ба “БДОО” гэсэн хайлтын 9, “бөөрний цочмог дутагдал” ба “нөөц хязгаарлагдмал орчин” гэсэн хайлтын 28 үр дүн, “бөөрний цочмог дутагдал” ба “нөөцийн хязгаарлагдмал орчин” гэсэн хайлтын 43 үр дүн дээр гарсан.

Дээрх хоёр хэлбэрийн хайлтын дүн 4 судалгаа давхардан гарсан бөгөөд 1 судалгаа нь адил гарчигтай байв. Эдгээр 75 судалгаанаас 58 нь агуулын холбоогүй байсан тул хасах шалгууруар хасагдсан. Үлдсэн 17 судалгаанаас 4 эргэмж ажиглалтын, 4 дагах ажиглалтын, 3 хяналтат судалгаа, 1 тойм, 1 зөвшөлцлийн зөвлөмж, 1 хөндлөн огтлолын судалгаа, 3 тохиолдлын тайлан гарсан байна. Дээрх 17 судалгааны ажлын эр сурвалж болон адил төстэй нийтлэл» гэсэн хэсгээс 11 судалгааг нэмж хамруулсан. Тэдгээрийн дотор тойм 4, дагасан ажиглалт судалгаа 4, эргэмж ажиглалт судалгаа 1, хөндлөн огтлолын судалгаа 2 хийгдсэн байв.

Мөн “Бөөрний цочмог гэмтэцийн оношилгоо”, “Нөөц хязгаарлагдмал орчин” гэсэн хайлтаас 13, “Бөөрний цочмог гэмтлийн оношилгоо”, “нөөцийн хязгаарлагдмал орчин” гэсэн хайлтаас 5 үр дүн гарчээ. Эдгээр судалгааны ажилууд нь өмнөх хайлтанд давхцан гарч ирсэн.

“Бөөрний цочмог гэмтлийн оношилгоо”, “нөөц хязгаарлагдмал орчин” гэсэн хайлтын үр дүнд 18 үр дүн гарсан тэднээс 14 судалгаа нь өмнөх хайлтанд гарч, үлдсэн 4 нь хасах шалгууруар хасагдсан. “Креатинин” ба “нөөц багатай орчин” гэсэн хайлтын дүнд 4 судалгаа олсон, тэдгээрээс 1 судалгаа өмнөх хайлтанд гарч, 2 нь хасах шалгууруар хасагдсан. Үлдсэн судалгаа нь хөндлөн огтлолын судалгаа байв. “хурдавчилсан тусламж”, “креатинин”, “өртөг” хэмээн хайлт хийхэд 65 үр дүн гарсан бөгөөд үүнээс зөвхөн 2 нь БДОО-той холбоотой байснаас 1 нь өмнөх хайлтнаас давхцан гарч ирсэн, үлдсэн нэг нь өртгийнхарьцуулсан судалгаа байв. Эдгээр нийтлэлийн эх сурвалжаас хөндлөн огтлолын нэг нэмэлт судалгаа олсон болно.

БДОО-ын COVID-19 халдварын үеийн БЦГ-ийн талаар нарийвчлан судалсан нотолгоо, эх сурвалж олдсонгүй.

Нотолгоо

БДОО-уудад БЦГ-ийг илрүүлэх, оношлох боломж нь харилцан адилгүй байдаг. Нөөц бололцоо нь хязгаарлагдмал зарим нэг эмнэлгүүдэд тодорхойлох боломжгүй байдаг ч ийлдсийн креатининыг хэмжих нь БЦГ-ийг илрүүлэх, хамгийн түгээмэл хэрэглэдэг аргачлал мөн.[1,34,37-49]

Товчоор хэлэхэд креатинин нь БЦГ-ийг оношилоход хэрэглэдэг лабораторийн хамгийн түгээмэл үзүүлэлт юм. 2015 оны олон улс дамнан хийгдсэн хөндлөн огтлолын судалгаагаар нийт тохиолдох БЦГ-ийн 63% нь зөвхөн ийлдсийн креатинины агууламж, хэмжээн дээр үндэслэн оношилсон болохыг тогтоожээ. БДОО-уудын дээрх эмнэлгүүдэд шээсний ялгаралтын хэмжээнд үндэслэн БЦГ-ийг оношилсон нь 28%-тай байв.[1]

Тайланд Улсын аймаг, бүс нутгийн эмнэлгийн 160 эмч нарын дунд 2018 онд хийсэн чанарын судалгаагаар дээр эмч нар БЦГ-ийг оношлох үйл ажиллагаандаа KDIGO шалгуурыг 37%, AKIN шалгуурыг 27.7% ба RIFLE шалгуурыг 26.1% нь тус тус мөрдөн ажилладаг гэжээ.[44] БДОО-уудын эрүүл мэндийн бүртгэлийн цахим сүлжээ,

дэд бүтэц хангалтгүйн улмаас тухайн өвчтөний ийлдсийн креатинины хэмжээ хэд байсан цаашид хэрхэн нэмэгдсэн зэргийг өвчний түүх, картаас тодорхойлох боломжгүйн улмаас БЦГ-ийг илрүүлэх оношилгоо хугацаа алдахад хүргэдэг байна.[34]

БДОО-уудад чиглэсэн нэг зөвшилцлөөс гаргасан зөвлөмжид өвчтөний ийлдсийн креатинин нэмэгдсэн тохиолдолд БЦГ-тэй хэмээн үзэж, ялган оношилж нотлогдох хүртэл дээрх оношийн дагуу хугацаа алдалгүй эмчлэхийг санал болгож байна.[50]

БДОО-д БЦГ-ийг илрүүлэх, оношилход ихэвчлэн ашигладаг үнэлгээний бусад аргачлалуудад шээсний ерөнхий шинжилгээ, бөөрний хэт авиан шинжилгээ, бөөрний биопси зэрэг хамаарна.[51] Хөндлөн огтлолын аргачлалаар хийсэн 2 судалгаанд БЦГ-ийг илрүүлэхэд коронавируст халдвараар өвдсөн өвчтөнүүдийн4% БЦГ-тэй байгааг оношилсон байна.[1,44] Африкийн дэд Сахар орчмын бүс нутагт шүлсэнд мочевин тодорхойлох түргэвчилсэн сорилыг ашигласан нь өвөрмөц, мэдрэмж сайтай, хямд, үр дүнтэй оношилгооны арга болох нь батлагдсан.[52-54]

Хэрэгжүүлэх боломж, эсрдэл хүндрэлээс сэргийлэхүй.

Эдгээр оношилгооны дээр арга аргачлалуудыг хэрэглэх боломж, нөөц улс орнуудад харилцан адилгүй байдаг. 2016 онд хийсэн судалгаагаар дэлхийн өнцөг булан бүрт ажиллаж байгаа 160 эрүүл мэндийн ажилтнуудын дунд судалгаа хийхэд хөдөө орон нутгийн эрүүл мэндийн анхан шатлалын эмнэлгүүдэд БЦГ-тэй тохиолдлуудын 84%-ийг нь эмнэлзүйн үзлэг, дүгнэлт дээр үндэслэн оношилсон байгаа нь тухайн шатлалд дээрх хүндрэлийг оношлох багаж хэрэгслийн хангамж боломж хомс байгааг харуулж байна.[57]

Нийт дүүргийн болон бүсийн түвшний II шатлалын эмнэлгүүдэд БЦГ-ийг илрүүлэх оношилгоонд шаардлагатай лабораторийн тоног төхөөрөмж тус бүр 63% ба 85%-тай байна гэдэг хангалтгүй үзүүлэлт хэмээн үзжээ.[57]Дээрх хүндрэлийг хугацаа алдалгүй оношлох мэдлэг дадлага бүхий хүний нөөцийн хүртээмжид үүнд бас нөлөөлдөг. Хөдөө орон нутгийн анхан шатны эмнэлэгт ажиллаж байгаа эмч нарт тулгарах эмнэлзүйн тохиолдол цөөн, харин нэгэнтэй учирвал нэн хүнд, цочмог тохиолдлууд байр тул оношлох дадлага туршлага дутагддаг.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний анхан шатны эрүүл мэндийн мэргэжилтнүүд, сувилагч, бага эмч нар болон БЦГ-ийн талаар мэдлэг багатай бусад нийгмийн эрүүл мэндийн ажилтнууд дээрх хүндрэлтэй эхлэн нүүр тулгардаг.[1,58,59] Нөөц багатай улс орнуудын нөхцөлд ЭМАШТ-ийн салбарт ажиллаж буй эмч, эмнэлгийн ажилтнуудад нефрологийн болон БЦГ-ийн талаарх мэдлэг, боловсрол дутмаг байгаа нь оношийг илрүүлэхэд хугацаа алдахад хүргэж болзошгүй юм.[60,61]

БЦГ-ийг эрт оношлоход эмнэлгийн мэргэжилтний мэдлэг чадвар болон лабораторийн хүчин чадлаас ихээхэн хамаардаг. Жишээлбэл, харьцангуй хямд оношилгооны хэрэгсэл болох ийлдсийн креатинины шинжилгээг өргөжүүлснээр БЦГ-ийг эрт оношилж, эмчилгээг эрт эхлэх боломжтой; дээрх аргачлалыг зөв зохистой хэрэглэх, үнэлэлт дүгнэлт хийх чадвартай хүний нөөцийн бэлтгэгдсэн байдал чухал ач холбогдолтой.[62-64]

2019 онд Өмнөд Африкт ХДХВ-ийн эмчилгээг хянах зорилгоор эмнэлэгт суурилсан тусламж, үйлчилгээний төв, лабораторид суурилсан шинжилгээний зардлаас креатинин тодорхойлох шинжилгээний зардал $6-аар илүү байсан.

Нэг өвчтөнд ногдох өртөг өндөр байгаа ч лабораторийн шинжилгээний чадварыг өргөтгөснөөр нэмэлт нөөц, дэд бүтэц, зардал шаардагддаг хэдий ч креатинины шинжилгээг орны дэргэд болон төвлөрсөн лабораторид хийх боломжтой байх нь оношилгоо эмчилгээний онц ач холбогдолтой байдаг. Нэмж дурьдахад креатинины шинжилгээг БДОО-уудад өвчтөний орны дэргэдэх хурдавчилсан хэлбэрээр хийх нөхцлийг бүрдүүлэх нь бодлогын хүрээнд шийдвэрлах нэн чухал асуудал мөн.[64,65]

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний дээрх шатлалд ажиллагсдыг хамарсан сургалтын санаачлагыг хэрэгжүүлэх нь хамгийн боломжтой, үр дүнтэй эхний алхам байх бөгөөд БЦГ-ийг илрүүлэх оношилгооны чадварыг сайжруулах хүчин чармайлтыг тухайн орон нутгийн дэд бүтэц, нөөцөнд тохируулан зохион байгуулах хэрэгтэй.

Зөвлөмж ба санал

1. COVID-19 халдвартай хийгээд ийлдсийн креатинины түвшин нэмэгдсэн өвчтөнийг БЦГ-тэй хэмээн үзэж эмнэлзүйн тухайн оношийг батлагдах хүртэл дээрх оношийн дагуу хугацаа алдалгүй тусламж үзүүлэх, эмчилгээ хийхийг зөвлөмжилж байна *(бага зэрэглэлийн зөвлөмж, нотолгооны чанар*

сул).

2. Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний шатлалд ийлдсийн креатинин ба шүлсний мочевиний хэмжээг тодорхойлох түргэвчилсэн шинжилгээ хийх боломж бололцоог бүрдүүлэхийг зөвлөмжилж байна *(бага зэрэглэлийн зөвлөмж, нотолгооны чанар нэн сул).*
3. Бүх шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудад ажиллагсдын дунд БЦГ-ийн талаарх мэдлэг, дадлыг сайжруулах сургалтыг хэрэгжүүлэн ажиллахыгзөвлөмжилж байна. Энэ сургалтын хөтөлбөрт COVID-19 халдвартай өвчтөнд БЦГ-ийн хүндрэл учрах зүй тогтол, тархалт зэргээс гадна өөрийн эмнэлгий нөөц бололцоонд тулгуурлан БЦГ-ийг илрүүлэх, оношлох хийгээд тусламж үзүүлэх арга аргачлалыг багтаан оруулсан байх шаардлагатай *(зөвлөмжийн зэрэглэлгүй, туршлаганд үндэслэсэн).*

Асуулт 3. БДОО-уудад COVID-19 халдварын улмаас БЦГ-ээр хүндэрсэн тохиолдлыг хэрхэн эмчлэх вэ, тухайн өвчтөнүүдийн хэнд нь бөөр орлуулах эмчилгээ шаардлагатай вэ?

Үндэслэл

БДОО-уудад БЦГ-ийн үед үзүүлэх тусламж, эмчилгээ нь төрөл бүрийн бэрхшээлтэй тулгардаг. COVID-19 халдварын улмаас учрах БЦГ-ийн тархалт өндөр, дээрх хүндрэлийн улмаас эмнэлгийн нас баралт нэмэгдэж, тухайн шатлалд БЦГ-тэй өвчтөнд үзүүлэх тусламж үзүүлэх талаар хийх судалгаа, үнэлгээ нэн чухал юм.[36]

Хайлтын үр дүн

PubMed-ийн мэдээллийн санд “бөөрний цочмог гэмтэл” ба “COVID-19” буюу MeSH-ийн нэр томъёогоор хайлт хийхэд 76 судалгаа илэрсэн. Англи хэл дээр хэвлэгдээгүй 1 судалгаа, хасах шалгууруар 59 судалгааг хассан. Үлдсэн 16 үр дүнгээс хэвлэлийн тойм 1, ажиглалтын судалгаа 1, системчилсэн тойм 1, дадлагын удирдамж 2 байв. Эдгээр судалгааны эх сурвалж, лавлагааг цаашид хөөж хайхад 5 нэмэлт судалгаа гарсан болно. Үүнд ажиглалтын судалгаа 3, тохиолдлын тайлан 2 байв. Google Scholar дээрх эдгээр хайлтын нэр томъёог ашиглан холбогдох нэмэлт 5 судалгаа олсон; Эдгээрээс ажиглалтын судалгаа 3, тохиолдлын тайлан 2 байв. COVID-19 халдвартай өвчтөнүүдийн эмгэг физиологи, гистопатологи болон БЦГ-ийн менежменттэй холбоотой мэдээллийг оруулахад үндэслэн сонирхсон судалгааг сонгосон.

PubMed-ийн мэдээллийн санд “орчих цусны эзлэхүүний менежмент» ба «COVID-19» гэсэн гарчиг/хураангуйгаар хайлт хийхэд 2 үр дүн гарчээ. Нэг судалгаа хасах шалгуурт орсон бөгөөд үлдсэн судалгаанууд нь хэвлэлийн тойм байв. Энэхүү судалгаатай холбоотой лавлагаа болон «адил төстэй нийтлэл» хэсгийг судалж үзэхэд холбогдох 10 нотолгоо нэмж олсон болно. Үүнд: хэвлэлийн тойм 4, ажиглах дадлага судалгаа 3, ажиглалтын судалгаа 1, системчилсэн тойм 1 байв. Бөөрний цочмог гэмтэл эсвэл COVID-19, уушгины цочмог өвчин, үжил зэрэгтэй холбоотой шингэн сэлбэлт эмчилгээний талаарх мэдээллийг үндэслэн судалгааг сонгосон.

Удирдамж дахь бусад асуултуудын хайлтын үр дүнд гарсан 5 холбогдох судалгааг ашигласан болно. Үүнээс хэвлэлийн тойм 2, ажиглалтын судалгаа 2, хөндлөн огтлолын судалгаа 1 байв. PubMed-ийн санд 2020 оны 8-р сарын 17-ноос өмнө хэвлэгдсэн бүх судалгааг энэ хайлтанд оруулсан болно. БДОО-ын COVID халдвартай холбоотой БЦГ-ийн тухай судалгаа олдоогүй тул өндөр орлоготой орнуудын COVID-19 халдвартай холбоотой БЦГ-ийн судалгаанууды үндэслэсэн болно.

Нотолгоо

Өндөр орлоготой орнуудад хийсэн судалгаанууд COVID-19 халдвар авагсдын дунд БЦГ-ийн хүндрэл 4.7%-75% хооронд хэлбэлздэгийг олж тогтоожээ.[67-73] Энэ бүлгийн өвчтөнүүдэд тохиолдох БЦГ-ийн тархалт нь нас, механик амьсгалуулалт, амьсгалын цочмог дистресс хамшинж (ARDS), вазопрессорын хамаарал, архаг хавсарсан өвчлөл, нас баралт зэрэгтэй холбоотой байсан.[67-69,72,74,75] COVID-19 халдварын улмаас учрах БЦГ-ийн тархалт өндөр, энэ хүндрэлийн улмаас өвчтөний нас баралтын хувь нэмэгддэг тул энэхүү зорилтот бүлгийн тусламж, эмчилгээ нь эмнэлзүйн ихээхэн анхаарал татсан асуудал болдог. Өнөөдрийг хүртэл хийсэн судалгаагаар тухайн хүндрэл учрах эмгэг физиологийн үндэс нь олон хүчин зүйлээс бүрдэх магадлалтай болохыг харуулж байна.[76-78]

Эмгэг судлалын шинжилгээгээр бөөрний түүдгэнцрийн үхжил үүссэн байх нь COVID-19 халдварын үед БЦГ үүсдэг гэсэн таамаглалыг баталсан.[71,79-83] Энэ талаар 26 өвчтөнд хийсэн бөөрний биопсийн шинжилгээнд бөөрний

түүдгэнцрийн үхжил үүссэн байжээ.[79] Энэхүү дүгнэлтийг бөөрний цусны урсгал буурах, халдвартай холбоотой цитокины идэвхжил, шуурга үүсэх, бөөрийг гэмтээх эмийн үйлдэлтэй холбон тайлбарлаж байна.[11]

Эмгэг судлалын шинжилгээгээр бөөрний түүдгэнцэр гэмтэж, бөөрний хялгасан судсанд тромбо үүссэний улмаас ишеми үүссэн зэрэг өөрчлөлтүүд нь БЦГ бий болсныг харуулах нотолгоо болдог. Мөн цитокины нөлөөгөр бөөрний гэмтэл үүссэнийг судлаачид нотолжээ.

Одоогийн байдлаар хөдөө хотын жижиг эмнэлгийн БЦГ-ийг үүсгэж буй шалтгааныг ялган оношлох, эмчлэх талаар бүгдээр хүлээн зөвшөөрсөн протокол байхгүй байна. Харин шинж тэмдгийн, дэмжих эмчилгээний зөвлөмжүүдийг гаргажээ. Хөдөөгийн анхан шатлалын эмнэлгүүдэд БЦГ-ийн тусламж үзүүлэх бололцоо боломж хумигдмал, тулгамдах асуудал олон байдаг. Бөөрний цусан хангамжийг буурахаас урьдчилан сэргийлэх зорилгоор кристаллойд уусмал сэлбэх эмчилгээ нь хөдөө, хотын бүх эмнэлгүүдэд хэрэглэх бололцоотой эмчилгээний хямд төсөр арга боловч нарийн нямбай хяналт хийх шаардлагатай.[24,71,86-89]

Шингэний тэнцвэр нэмэх (илүүдэлтэй) гарахнь уушгины цочмог гэмтэл, үжил бүхий өвчтөнүүдийн хувьд үр дүн муу байгаа бол консерватив буюу шингэний тэнцвэрийн сөрөг байх нь уушгины үйл ажиллагааг сайжруулж, эрчимт эмчилгээний тасагт эмчлэгдэх хоногийг бууруулж байгаа нотолгоо олонтой гарсан байна.[20,87,90-93]COVID-19 халдвартай өвчтөнүүдийн БЦГ-ийг эмчлэх зөвлөмжид хөнөөлт цитокиныг ялгахараас урьдчилан сэргийлэх зорилгоор механик амьсгалуулалтыг хийх явцдаа баротравма-ийг бууруулах аргачлалыг хамруулах шаардлагатай.[71]

Хэрэгжүүлэх боломж, эсрдэл хүндрэлээс сэргийлэхүй.

Эрүүл мэндийн дэд бүтэц, хүний нөөц, БДОО-уудын нөхцөл болон санхүүжилтийн олон хүчин зүйлээс шалтгаалан эмчилгээ, тусламжийн цар хэмжээ төрөл бүрийн шатлалд хэрэгжинэ. 2015 онд янз бүрийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний олон шатлалд БЦГ-д үзүүлэх тусламж үйлчилгээний төрлийг тодорхойлох талаар хийсэн хөндлөн огтлолын судалгаагаар БДОО-уудад тохиолдох нийт өвчтөнүүдийн 92%-д кристаллойд шингэнийг эмчилгээний үндсэн сонголт болгон ашиглаж байгааг харуулсан.

Мөн дээрх өвчтөнүүдийн 73.9%-д антибиотик эмчилгээ, 36.1%-д шээс хөөх эмчилгээг хийсэн байна.[1]2016 онд БДОО-уудад нөөц бололцоо хязгаарлагдмал нөхцөлд бөөрний эмгэгийг эмчилж буй 160 эмч нарын дунд явуулсан судалгаагаар мужийг төв, бүс нутгийн бараг бүх эмнэлгүүд амаар болон судсаар сэлбэх шингэн, антибиотик эмчилгээ хийх боломжтой байсан бол харин хөдөө орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын дөнгөж 52-60% нь судсаар шингэн, антибиотик эмчилгээ хийх боломжтой байгааг тогтоожээ.[57]

БЦГ-ийн үед үзүүлэх тусламж, эмчилгээний боломж, нөөц бололцоо нь БДОО-уудад, ялангуяа алслагдсан болон орон нутгийн эрүүл мэндийн тулсламж үйлчилгээний шатлалд байнгын бэрхшээлтэй тулгарсаар ирсэн. Шингэний зүгшрүүлэг эмчилгээг БЦГ-ийн эхний шатлалд хэрэглэхэд үр дүнтэй.

Харин шингэн сэлбэх эмчилгээ хийх мэдлэг боловсрол, султай ажилтан шингэн зүгшрүүлэг эмчилгээг БЦГ-тэй, амьсгалын цочмог дистресс хамшинжтэй, амь тэнссэн төлөвт орших өвчтөнд нямбай хяналтын дор зөв зохистой тун хэмжээгээр хийхгүй бол нэн аюултай гэдгийг олон нотолгоо харуулжээ.[89,92,94,95]

Үжлийн улмаас эрчимт эмчилгээний тасагт эмчлэгдэж буй 1808 хүнд хийсэн судалгаагаар их хэмжээний шингэнийг судсаар сэлбэж, шингэний тэнцвэрийг илүүдэлтэй байлгасан тохиолдолд нас барах эрсдэл нэмэгэж байгааг нотлон харуулсан.[96] COVID-19 халдварын улмаас механик амьсгалуулалттай, амь тэнссэн байдалтай өвчтөний шингэний тэнцвэрийг ямагт сөрөг хэмжээнд байлгахыг зөвлөж байна.[87,97]

Зааварчилгаа ба зөвлөмж (Хүснэгт 1)

1. COVID-19 халдварын улмаас БЦГ илэрсэн тохиолдолд эмнэлзүйн эхний шатанд судсаар кристаллойд шингэнийг зохих тунгаар сэлбэж зүгшрүүлэх эмчилгээ хийхийг зааварчилж байна *(өндөр зэрэглэлийн зөвлөмж, нотолгооны чанар сул)*.
2. COVID-19 халдвартай эмнэлзүйн нэн хүнд байдалтай өвчтөнүүдийг зүгшрүүлэх эмчилгээний шингэн сэбэлтийн хэмжээг аль болох бага хэмжээнд байлгахыг зааварчилж байна.Боломжтой бол шингэний тэнцвэрийг сөрөг утгатай байлгах заалттай *(өндөр зэрэглэлийн зөвлөмж, нотолгооны чанар сул)*.
3. Механик амьсгалуулалтыг уушги-хамгаалах аргачлалаар удирдаж, бөөр

гэмтээгч цитокин ялгарахуулахаас урьдчилан сэргийлэхийг зөвлөж байна.

Асуулт 4. COVID-19 халдварын улмаас БЦГ-д өртсөн өвчтөнүүдэд диализын хүртээмж үр ашгийг оновчтой болгох ямар боломжууд байна вэ?

Үндэслэл

COVID-19 халдварын улмаас хоёрдогчоор БЦГ үүсэх нь олонтой тохиолддог бөгөөд энэ нь цаашид нас баралтыг нэмэгдүүлдэг.[7,98,99] Африкийн Сахар орчмын өмнөд хэсэгт хийсэн БЦГ-ийн судалгаанд диализ эмчилгээг хийсний дараа нас баралт эрс буурсан болохыг харуулсан.[100] Харамсалтай нь БДОО-уудад тоног төхөөрөмж, хүний нөөц, санхүүжилт хязгаарлагдмал байдаг тул БЦГ-ийн үед диализ эмчилгээ хийх дутагдалтй байдаг.[101] Диализ эмчилгээ нь COVID-19 халдварын үеийн БЦГ-ийн эмчилгээнд чухал үүрэгтэй.

Хайлтын үр дүн

PubMed-ийн мэдээллийн санд дээр MeSH-ийндараах нэр томъёог ашиглан тус санд 2020 оны 8-р сарын 14-ний өдрийг хүртэл байршсан нотолгоонд хайлт хийв. Үүнд: ‘Бөөрний цочмог гэмтэл’, ‘нөөцийн хязгаарлагдмал’, ‘COVID’, ‘бага, дунд орлоготой орнууд’, ‘нөөц багатай орчин’, ‘хөгжил буурай орнууд’, ‘бөөр орлуулах эмчилгээ’, ‘гемодиализ’, ‘хэвлийн диализ’, ‘зардал-үр ашиг’, ‘өртөг’, ‘саад бэрхшээл’, ‘үр ашиг’ хэмээх үгүүдээр хайлт хийж 40 судалгааг тодорхойлов. Эдгээр судалгаанд тусгагдсан эх сурвалжийг хөөн тодруулахад 6 судалгаа нэмэгдэж гарсан. Судалгааны дийлэнх нь ажиглалтын судалгаа, тойм байв. Тодорхойлогдсон нийт судалгааны бараг тэн хагас нь санамсаргүй хяналттай туршилт буюу зардлын шинжилгээ, техник эдийн засгийн үндэслэл зэрэг байв. Мөн системчилсэн тойм судалгаа 2-ыг хамруулав. Бөөр орлуулах эмчилгээний хувилбаруудын харьцуулан судалсан 18 судалгаа нь ӨОО болон БДОО-уудад суурилан хийсэнбайв.

Нотолгоо

БДОО-д тохиох БЦГ-тэй өвчтөнүүдийн дунд диализ эмчилгээний хэрэгцээ өндөр байдаг.[1,34,42,102]БЦГ-ийн үеийн диализ эмчилгээг зөвхөн тухайн бүс нутгийн эрүүл мэндийн байгууллагуудаар дамжуулан авах боломжтой бөгөөд эдгээр эмнэлгүүдийн нөөц бололцоо хийгээд хүртээмж мөн л хангалтгүй байдаг.

БДОО зарим оронд хийсэн диализ эмчилгээний хүртээмжийн тухай судалгаагаар диализ эмчилгээний заалттай бүх судалгаанд оролцогчид эмчилгээний сеанс хийлгэх боломжтой байсан гэж мэдээлсэн байхад бусад судалгаанд энэ эмчилгээнд хамрагдахад саад бэрхшээлтэй байсан талаар мэдээлсэн. 2015 онд Уганда улсын БЦГ-тэй өвчтөнүүдийн дунд хийсэн үр дүнгийн талаарх судалгаагаар БЦГ-ийн улмаас эмнэлэгт нас баралтын түвшин 21% байгааг мэдээлсэн бөгөөд нөхцөл байдал нь гемодиализ эсвэл эрчимт эмчилгээний тасагт эмчлүүлэх шаардлагатай өвчтөнүүдийн дунд нас баралтын дийлэнх хувийг эзэлж энэ тулгарч буй асуудал нөөц бололцоотой холбоотой байсныг дурджээ.[42]

Африкийн Сахар орчмын өмнөд хэсэгт БЦГ-ийн үр дүнг судалж буй өөр нэг судалгаагаар судалгаанд хамрагдсан насанд хүрсэн өвчтөнүүдийн дөнгөж 33% нь шаардлагатай үед диализ эмчилгээ хийлгэсэн болохыг тогтоожээ.[102]Диализ эмчилгээний зардлыг өвчтөнүүд өөрсдөө төлдөг учраас санхүүгийн дарамт хүнд асуудал болон тулгардаг.[102-105]

БДОО-уудын гемодиализ эмчилгээ хийх боломжтой эрүүл мэндийн байгууллагуудын ихэнх нь зөвхөн завсарлагат гемодиализ хийх боломжтой байдаг бөгөөд тухайн диализын тоног төхөөрөмжийн ашиглалт, хэрэглээг 69% -95% гэж мэдээлжээ.[1,44] Судалгаанд хамрагдсан зарим орнуудад хэвлийн диализ болон диализын хялбаршуулсан төхөөрөмжийг (SLED) хэрэглэдэг ажээ. [1,34]

Хэвлийн диализийн эмчилгээг хийх нь БЦГ-ийн БДОО-уудад бөөр орлуулах эмчилгээний нэг практик чиг хандлага юм.[106] Олон улсын нефрологийн нийгэмлэгээс боловсруулсан 0by25 санаачилга нь БЦГ-ийн оношилгоо, эмчилгээний ач холбогдол, ялангуяа БДОО-уудад нэн ач холбогдолтой болохыг анхаарч үзсэн болно. “Залуусын амьдралыг аврах” хөтөлбөр (ISN-ийн консорциум, Хэвлийн диализын олон улсын нийгэмлэг, Хүүхдийн нефрологийн олон улсын холбоо, Евро-ХД, Бөөрний тогтвортой тусламжийн сан) нь БДОО-уудад БЦГ-ийг эмчлэхэд хэвлийн диализыг ашиглахыг дэмжиж сурталчилсан. Дээрх хөтөлбөр нь эмч, сувилагчдын сургалтыг дэмжиж, техникийн туслалцаа үзүүлж, хэвлийн диализыг тухайн орон нутагт дэлгэрүүлэх, дээрх технологийг практикт нэвтрүүлэх зардлыг нөхөхөд тусалсан.[107,108]

Vasudevan ба бусад эрдэмтэд Энэтхэг улсад хийсэн судалгаанд хамрагдсан 26 төвийн 23-т гемодиализ, хэвлийн диализ, тасралтгүй

бөөр орлуулах эмчилгээ (CRRT), SLED зэрэг аргачлалууд боломжтой байсан ч хэвлийн диализ нь өртөг багатай, хийхэд хялбар энгийн байдаг тул хамгийн тохиромжтой хэмээн үнэлсэн.[109]Цаашилбал, McCulloch ба бусад эрдэмтдийн судалгаагаар хэвлийн диализ нь Африкт бөөр орлуулах эмчилгээний хамгийн өргөн ашигладаг арга болохыг мэдээлэв.[110]

БЦГ-д хэвлийн диализын хэрэглээний талаар Бразил улсад саяхан хийсэн санамсаргүй тохиолдлын эмнэлзүйн туршилтаар бөөр орлуулах дээрх аргачлал нь метаболизмын алдагдлыг арилгах, халдвар ба хүндрэлийн хувь хэмжээ, бөөрний үйл ажиллагаа сэргэх, өвчтөний эсэн мэнд үлдэх, нас баралт зэрэг үзүүлэлтүүдээр гемодиализын дараах үр дүнтэй алил хэмжээнд байсныг нотолжээ.[111]

Непал улсын зүүн хэсэгт явуулсан судалгаагаар сувилахуйн ажилтнууд, техникчид, эмч нарыг БЦГ-ийн үед хэвлийн диализ эмчилгээ хийх талаар сургалтанд хамруулахад үр дүнтэй байсан.[112] Африкийн дэд Сахар орчмын өмнөд хэсэгт БЦГ-ийн улмаас гемодиализ болон хэвлийн диализ эмчилгээ хийлгэсэн хүүхдүүдийн хоорондын системчилсэн харьцуулсан судалгаа хийхэд нас баралтын ялгаа байхгүй болохыг тогтоожээ.[100]

2013 онд хийсэн өөр нэг системчилсэн тойм судалгаанд хэвлийн диализ ба гемодиализын хоорондох үр дүнгийн хувьд мэдэгдэхүйц ялгаа байхгүй гэсэн дүгнэлтэд хүрсэн.[113]Нигери улсад хийсэн өөр нэг судалгаагаар хэвлийн диализ ба гемодиализ аль аль нь уремийн хэмжээ болон ийлдсийн мочевин, креатинин, калийн хэмжээ мэдэгдэхүйц бууруулсан болохыг харуулсан.[114]

COVID-19 халдварын үеийн БЦГ-ийн менежментийн талаарх судалгаа одоог хүртэл нэмэгдэн гарч ирсээр байна. Олон судалгаанууд нь COVID-19 өвчтэй хүмүүст бөөр орлуулах эмчилгээ (RRT) хийхэд тулгардаг бэрхшээлүүдийг судалж үзсэн тойм судалгаа юм.Ихэнх тоймууд нь өндөр орлогт орнуудын жишээн дээр хийгдсан боловч COVID-19 цартахлын үед БЦГ-ийг эмчлэг тоног төхөөрөмж, хүний нөөцийн хомсдолыг судалсан тул БДОО-уудыд хувьд ихээхэн ач холбогдолтой юм.

COVID-19 халдварын үеийн БЦГ-ийг эмчлэхэд хэрэглэсэн гемодиализ эмчилгээ нь олон өвчтөнд цусны бүлэгнэлтийн алдагдалд хөтлөх бөгөөд тэдэнд цус бүлэгнэлтийн алдагдал гипо-гиперкоагуляцийн хэлбэрээр илрэх тул дээрхтохиолдолд хэвлийн диализ эмчилгээ нь нэн тохиромжтой хувилбар юм.

COVID-19 өвчтөнд хэвлийн диализын катетер байрлуулах аюулгүй байдал, үр нөлөөг судалж үзсэн нэг судалгаагаар хоёр хүний бүрэлдэхүүнтэй багт байрлуулах боломжтой бөгөөд хэвлийн хөндийд диализын гуурс (катетер) байрлуулснаас хойш хоёр долоо хоногийн хугацаанд аюулгүй гэж дүгнэжээ.[115,116]

Одоогийн судалгаагаар хэвлийн диализ явцад хэвлийг угаасан шингэн вирус агуулаагүй, халдвар тараах эрсдэлтэй гэсэн мэдээлэл, нотолгоо алга байна.[117] Саяхан хэвлэгдсэн нэгэн судалгаанд хэвлийн шингэнд ПГУ-аар вирус илэрсэн гэх боловч тухайн тохиолдолд халдвартай вирус байгаа эсэх нь тодорхойгүй байгаа бөгөөд үүнээс өөр тохиолдол бүртгэгдээгүй байна.[118]

Өмнөд Африкт хэвлэгдсэн тойм нийтлэлд COVID-19 халдвартайөвчтөнүүдийн БЦГ-ийг хэвлийн диализыг ашиглан эмчлэх талаар хийсэн судалгааны дүн, диализыг ашиглахад тулгардаг давуу тал, бэрхшээлийг нэгтгэн тусгажээ.[115]Энэхүү тоймд COVID-19 халдварын үед учрах БЦГ-ийг хэвлийн диализын аргаар эмчлэхэд хамгийн чухал давуу талуудын нэг нь сувилагчийн хэрэгцээ, харьцаа бага, диализ эмчилгээ хийхэд сувилагчийн оролцоо бага шаардагддаг тул цартахлын үед хамгийн тохиромжтой арга мөн гэж үзжээ.[119]

Өөр нэг судалгаанд хэвлийн диализын шингэнийг сэлбэх, солиход сувилахуйн мэргэжилгүй туслагчийг ашиглах боломжтой дээрх аргачлалыг элдэв хүндэрлүүй хийж болно гэж онцолжээ.[120]

Хэрэгжүүлэх боломж, эсрдэл хүндрэлээс сэргийлэхүй.

БДОО-ын диализын эмчилгээ хийх бололцоо орон бүрт өөр өөр түвшинд байна. Дээрх эмчилгээг хийлгэх төлбөр диализын хүртээмжийг өргөжүүлэхэд хамгийн их бэрхшээл учруулж байна. Гемодиализ ба хэвлийн диализ аль аль нь БДОО-д түгээмэл хэрэглэгддэг боловч хэвлийн диализ нь өртөг багатай болох нь батлагдсан бөгөөд 2011 оны судалгаагаар хэвлийн диализ нь гемодиализ эмчилгээний зардлын талаас баг хувийг эзэлдэг болохыг тогтоожээ.[121,122]

Нэмж дурдахад хэвлийн диализ нь гемодиализ эмчилгээтэй харьцуулахад нэн хялбар технологи ашигладаг, цахилгаан шаарддаггүй тул хөдөө орон нутаг эсвэл орон гэрийнхээ нөхцөлд дээрх эмчлилгээг хэрэглэх боломжтой байдаг.[123]

Диализын тоног төхөөрөмжөөр хангахад шаардагдах зардал, дэд бүтцийн бэрхшээлээс гадна бэлтгэгдсэн хүний нөөц дутагдалтай байгаа

нь нөөц багатай олон орны нөхцөлд тулгамдсан асуудал болж байна.[123,124] Хүний нөөцийн энэхүү дутагдлыг улс орнууд янз бүрээр шийдвэрлэж байна.

Танзани улсад эмнэлгийн мэргэжилтнүүдийг хэвлийн диализ хийх ур чадварыг эзэмшүүлэх 5 долоо хоногийн сургалтын хөтөлбөрт үнэ төлбөргүй хамруулан туршиж үзсэн нэг судалгаагаар бэлтгэгдсэн сувилагчдын дунд ур чадвараа хөгжүүлж,тухайн аргачлалтыг хэрэгжүүлэх нөөц боломж байгаа газруудад хэвлийн диализыг осол хүнрэлгүйзөв удирдан зохион байгуулах боломжийг бүрлүүлжээ.[124]

Диализын эмчилгээнд тулгардаг хамгийн том саад бэрхшээл бол өвчтөнүүд диализын зардлыг хэрхэн төлөх асуудал юм. Энэхүү бэрхшээлийг зарим улс орон амжилттай шийдвэрлэн ажиллаж байна. Жишээлбэл, 2007 онд Тайландад бүх нийтийн хамарсан диализын хөтөлбөрийг хэрэгжүүлж, “Хэвлийн диализ-анхдагч эмчилгээ” бодлого хэрэгжүүлж, үүгээр дамжуулан диализ эмчилгээ шаардсан өвчтөнүүд төлбөрөө өөрсдийн түрээвчээс бус засгийн газрын нөөцөөс нөхөн төлүүлсэн. Энэ нь хэвлийн диализын хэрэглээг 2012 онд 10% -иас 23.1% хүртэл нэмэгдүүлсэн байна.[125]Эмч нар засгийн газар болон төрийн бус байгууллагуудтай түншлэх нь диализыг өвчтөнд илүү хүртээмжтэй болгохын тулд санхүүжилтийн бодлогыг сайжруулах боломжтой юм.[126]

Танзани улсад БЦГ-ийн улмаас хийх нэг хэвлийн диализын нэг сеансийн эмчилгээнд хамрагдах дундаж өртөг: хэвлий угаах уусмал-$24-40; хэвлийн гуурс зөөлөн, хатуугаар хамаарч $6.30-30 байсан бөгөөд нийт зардал нь 788 ам.доллар байсан нь ДЭМБ-ын ангилалд заасны дагуу зардал хэмнэлтэй өртөг: үр дүн өндөртэй аргачлал гэдэг нь нотлогдож байна.[126] Танзани улсын хойд хэсэгт явуулсан өөр нэг судалгаанд эмчилгээнд хамрагдсан тохиолдол бүрийн хэвлийн диализын өртөгт (диализын хоногийн хувьсах тоо шаардагдах) дүн шинжилгээ хийжээ.[124]

Энэ судалгаанд хамрагдсан 14 тохиолдлыг үндэслэн өртөг ба зах зээлийн үнэд суурилсан өртөгийг харьцуулсан болно. БЦГ-ийн улмаас хийх бүтэн курс эмчилгээний дундаж өртөг 420 ам доллар байсан бол хувийн хэвшлийн байгуулагууд хийхэд $788 ам доллар байжээ.[126]

Дээрх нотолгооны эсрэгээр Энэтхэг, Бразил, Нигери, Өмнөд Африк зэрэг орнуудад гемодиализ болон хэвлийн диализ эмчилгээний өртөг ойролцоогоор адил байгааг нэг судалгаагаар тогтоожээ.[128]Худалдаанд бэлтгэсэн диализын уусмалуудыг худалдан авахад шаардагдах зардал, тээвэрлэлтийн бэрхшээлийг харгалзан Өмнөд Африкийн нэг төвд судсаар сэлбэдэг шингэнийг суурь болгон ашиглаж, хэвлийн диализын уусмалыг орон нутагтаа үйлдвэрлэн, хэвлийн диализыг өөрдийн бэлтгэсн уусмалыг ашигласан тухай туршлагаа мэдээлэв.[129]

Тэд хэвлийн гялтангийн үрэвсэл үүсэх хүндрэл 4% (2/49 өвчтөн), хэвлийн диализаас үүдэлтэй электролитийн хоёрдогч алдагдал илрээгүй болохыг тогтоожээ. Олон тооны бусад судалгаанаас харахад хэвлийн диализыг түгээмэл ашиглах тутам орон нутгийн шинэ шийдлүүд төрөн гарах болно.[130]

Орон нутагт үйлдвэрлэсэн хэвлийн диализын уусмалыг худалдааны зорилгоор үйлдвэрлэсэн хэвлийн диализын уусмалуудтай харьцуулсан нэг судалгаагаар хэвлийн гялтангийн үрэвсэл нь тухайн орон нутгийн уусмалаар эмчилсэн өвчтөнүүдийн 16%-д тохиолддог бөгөөд энэ нь худалдааны зориулалттай хийсэн уусмалын хувьтай ойролцоо байв.[131]

Зааварчилгаа болон зөвлөмж (Хүснэгт 1)

